



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган суман дахь сум дундын Ойн ангийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** БУА-2023/158/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

Булган аймаг  
2023 он

Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд  
Тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ  
Утас: 7034-2580 Цахим хаяг: [Erdeneb@audit.gov.mn](mailto:Erdeneb@audit.gov.mn)

Аудитын менежер: Ж.Энхцоодол  
Утас: 7034-2716 Цахим хаяг: [enkhtsoodolj@audit.gov.mn](mailto:enkhtsoodolj@audit.gov.mn)

Ахлах аудитор: Д.Анхбаяр  
Утас: 7034-2495 Цахим хаяг: [Ankhubayard@audit.gov.mn](mailto:Ankhubayard@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **АГУУЛГА**

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	3
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
4.5.1 Завсрын аудитын талаар.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	18
5.1 Төлбөрийн акт .....	18
Төлбөрийн акт тогтоогдоогүй болно.....	18
5.2 Албан шаардлага .....	18
5.3 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхлагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-2580  
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.02.24 № 218

танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

БУЛГАН АЙМГИЙН БУЛГАН СУМАН  
ДАХЬ СУМ ДУНДЫН ОЙН АНГИЙН  
ДАРГА Б.АЛТАНСҮХ ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган аймаг дахь мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган аймгийн Булган суман дахь сум дундын ойн ангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

"Тэр бум мод" үндэсний хөдөлгөөнтэй холбогдуулан мод, бут тарих ажил нэмэгдэж, хууль, хүчний байгууллагууд тарьц, суулгац ургуулах зорилгоор үр, мөчир бэлтгэх үрийн модны плантаци байгуулах ажил гэх мэт үйл ажиллагааны талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн байна. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явагдсан ч мод үржүүлгийн ажил хүний нөөцөөс болон хөрөнгө санхүүжилтгүйн улмаас хэрэгжээгүй байна.

#### Аудитын гол асуудал

2022 онд орон нутгийн төсвийн захирагчаас 48,556.2 мянган төгрөг, үйл ажиллагааны орлого 40,615.1 мянган төгрөг, нэмэлт санхүүжилт 47,889.2 мянган төгрөг

авсан, 2022 оны авлагын эцсийн үлдэгдэл 13,229.6 мянган төгрөгийн авлагын барагдуулаагүй, өглөгийн данс нь эхний болон эцсийн үлдэгдэлгүй байна.

Булган аймгийн Булган суман дахь сум дундын ойн ангийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал илрээгүй байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>17268682.05</u>	<u>41787152.80</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	17268682.05	28557542.80
351	Түүхий эд материал	10948550.80	22083000.80
35110	Тусгай зориулалттай материал	10948550.80	22083000.80
354	Хангамжийн материал	6320131.25	6474542.00
35410	Бичиг хэргийн материал	167800.00	211000.00
35420	Аж ахуйн материал	5249316.00	4047542.00
35430	Сэлбэг хэрэгсэл	749500.00	2216000.00
35440	Түлш, шатах тослох материал	153515.25	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>35837431.16</u>	<u>99876668.46</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	35837431.16	99876668.46
392	Биет хөрөнгө	35837431.16	76157840.46
39203	Авто-тээврийн хэрэгсэл	70850000.00	117335714.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-42260000.40	-53976428.88
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	7828849.00	11120649.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-1570750.56	-2781932.38
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1370000.00	3875257.46
39208	Хуримтлагдсан элэгдэл	-380666.88	-2694697.08
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>53106113.21</u>	<u>141663821.26</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>53106113.21</u>	<u>141663821.26</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	53106113.21	141663821.26
512	Хуримтлагдсан үр дүн	53106113.21	141663821.26
51210	Өмнөх үеийн үр дүн	53106113.21	53106113.21
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>53106113.21</u>	<u>141663821.26</u>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	108047175.00	224,635,547.72
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	24175400.00	128,190,147.72
120	Нийтлэг татварын бус орлого	24175400.00	128,190,147.72
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	24175400.00	128,190,147.72
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	24175400.00	53,844,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	83871775.00	96,445,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	51452375.00	47,889,200.00
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	32072875.00	47,889,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19379500.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	32419400.00	48,556,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	32419400.00	48,556,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	95210520.84	136,077,839.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	95210520.84	136,077,839.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	82058612.84	89,113,294.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	33781182.00	36,596,529.00
210101	Үндсэн цалин	27403541.00	34,471,588.00
210102	Нэмэгдэл	5431086.00	1,289,901.00
210104	Урамшуулал	946555.00	835,040.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4614610.00	4,327,621.64
210201	Тэтгэврийн даатгал	3313926.67	3,110,703.76
210202	Тэтгэмжийн даатгал	361718.93	365,965.34
210203	ҮОМШӨ-ний даатгал	282184.19	292,772.26
210204	Ажилгүйдлийн даатгал	54548.53	43,550.26
210205	Эрүүл мэндийн даатгал	602231.68	514,630.02

2104	Хангамж, бараа материалын зардал	3160872.00	4,686,587.25
210401	Бичиг хэрэг	357700.00	301,000.00
210402	Тээвэр, шатахуун	2173172.00	3,997,187.25
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	630000.00	388,400.00
2105	Нормативт зардал	1271399.00	845,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1271399.00	845,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	70500.00	650,500.00
210604	Урсгал засвар	70500.00	650,500.00
2107	Томилолт, зочны зардал	262000.00	160,000.00
210702	Дотоод албан томилолт	262000.00	160,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25587325.00	27,214,195.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25337725.00	26,982,195.00
210803	Даатгалын үйлчилгээ	106000.00	79,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	99600.00	119,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44000.00	33,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13310724.84	14,632,861.42
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1835950.00	1,239,824.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	11474774.84	13,195,038.42
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13151908.00	46,964,545.36
2132	Бусад урсгал шилжүүлэг	300000.00	9,412,050.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300000.00	298,650.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	12851908.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	12851908.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>12836654.16</u>	<u>88,557,708.05</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>12836654.16</u>	<u>88,557,708.05</u>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>108047175.00</u>	<u>137,060,490.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	24175400.00	40,615,090.00
120	Нийтлэг татварын бус орлого	24175400.00	40,615,090.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	24175400.00	40,615,090.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	24175400.00	40,615,090.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	83871775.00	96,445,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	51452375.00	47,889,200.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	32072875.00	47,889,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19379500.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	32419400.00	48,556,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	32419400.00	48,556,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>88667675.00</u>	<u>134,080,690.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	88667675.00	134,080,690.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	75515767.00	87,116,144.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	33781182.00	36,596,529.00
210101	Үндсэн цалин	27403541.00	34,471,588.00
210102	Нэмэгдэл	5431086.00	1,289,901.00
210104	Урамшуулал	946555.00	835,040.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4614610.00	4,327,621.64
210201	Тэтгэврийн даатгал	3313926.67	3,110,703.76
210202	Тэтгэмжийн даатгал	361718.93	365,965.34
210203	ҮОМШӨ-ний даатгал	282184.19	292,772.26

210204	Ажилгүйдлийн даатгал	54548.53	43,550.26
210205	Эрүүл мэндийн даатгал	602231.68	514,630.02
2104	Хангамж, бараа материалын зардал	2810500.00	3,647,500.00
210401	Бичиг хэрэг	280500.00	340,000.00
210402	Тээвэр, шатахуун	1900000.00	2,919,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	630000.00	388,400.00
2105	Нормативт зардал	450000.00	450,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	450000.00	450,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	675000.00	2,243,700.00
210604	Урсгал засвар	675000.00	675,000.00
2107	Томилолт, зочны зардал	262000.00	160,000.00
210702	Дотоод албан томилолт	262000.00	160,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32322475.00	39,492,795.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	32072875.00	39,260,795.00
210803	Даатгалын үйлчилгээ	106000.00	79,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	99600.00	119,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44000.00	33,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	600000.00	197,999.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	400000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	200000.00	197,999.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13151908.00	46,964,545.36
2132	Бусад урсгал шилжүүлэг	300000.00	9,412,050.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300000.00	298,650.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	12851908.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	12851908.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>19379500.00</u>	<u>2,979,800.00</u>

8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	19379500.00	-
---	--	-------------	---

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	51,607,529.05		51,607,529.05
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	51,607,529.05	-	51,607,529.05
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-		-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-		-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	1,498,584.16		1,498,584.16
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	53,106,113.21	-	53,106,113.21
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	53,106,113.21	-	53,106,113.21
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	53,106,113.21	-	53,106,113.21
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-		-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-		-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-		-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	88,557,708.05		88,557,708.05
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	141,663,821.26	-	141,663,821.26

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	67807700	99507994.64	- 31700295	146.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	67807700	96528194.64	- 28720495	142.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	58394300	87116144.64	- 28721845	149.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	46253800	36596529	9657271	79.12

210101	Үндсэн цалин	38,559,200.00	34,471,588.00	4087612	89.4
210102	Нэмэгдэл	5040600	1289901	3750699	25.59
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	5786500	4327621.64	1458878	74.79
210201	Тэтгэврийн даатгал	3934800	3110703.76	824096.2	79.06
210202	Тэтгэмжийн даатгал	463000	365965.34	97034.66	79.04
210203	ҮОМШӨ-ний даатгал	370300	292772.26	77527.74	79.06
210204	Ажилгүйдлийн даатгал	92600	43550.26	49049.74	47.03
210205	Эрүүл мэндийн даатгал	925800	514630.02	411170	55.59
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3664100	3647500	16600	99.55
210401	Бичиг хэрэг	200000	340000	-140000	170
210402	Тээвэр, шатахуун	2914100	2919100	-5000	100.17
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	550,000.00	388,400.00	161600	70.62
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	450,000.00	450,000.00	0	100
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	450,000.00	450,000.00	0	100
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	675,000.00	2,243,700.00	-1568700	332.4
210604	Урсгал засвар	675,000.00	675,000.00	0	100
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	160,000.00	160,000.00	0	100
210702	Дотоод албан томилолт	160,000.00	160,000.00	0	100
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,204,900.00	39,492,795.00	38287895	3277.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	851,500.00	39,260,795.00	38409295	4610.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох			0	
210803	Даатгалын үйлчилгээ	159,000.00	79,500.00	79500	50
210804	Тээврийн хэрэгслийн татвар	149,400.00	119,500.00	29900	79.99
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	45,000.00	33,000.00	12000	73.33
210807	Газрын төлбөр		-	0	
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	200,000.00	197,999.00	2001	99
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		-	0	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	200,000.00	197,999.00	2001	99
<b>211</b>	<b>ХҮҮ</b>	-	-	0	
<b>2111</b>	<b>Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр</b>	-	-	0	

2112	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	-	-	0	
212	ТАТААС	-	-	0	
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	-	-	0	
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	-	-	0	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,413,400.00	9,412,050.00	1350	99.99
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-	0	
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,413,400.00	9,412,050.00	1350	99.99
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	298,650.00	1350	99.55
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>2,979,800.00</b>	<b>2,979,800.00</b>	0	100
2200	Дотоод эх үүсвэрээр	2,979,800.00	2,979,800.00	0	100
2260	Гадаад эх үүсвэрээр	-	-	0	
23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	-	-	0	
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	72,356,200.00	89,171,290.00	-	123.24
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-	0	
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	48,556,200.00	48,556,200.00	0	100
132001	Орон нутгийн төсвөөс	48,556,200.00	48,556,200.00	0	100
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-	0	
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	-	-	0	
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	23,800,000.00	40,615,090.00	-	170.65
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	23,800,000.00	40,615,090.00	-	170.65
122	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	-	-	0	
122002	Хандив тусламж /гадаад/	-	-	0	
14	<b>БУСАД ЭХ ҮҮСВЭР</b>	-	-	0	
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	-	-	0	
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	5	5	0	100
620001	Удирдах ажилтан	1	1	0	100
620002	Гүйцэтгэх ажилтан	2	2	0	100
620003	Үйлчлэх ажилтан	2	2	0	100
63	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	-	-	0	
630	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	-	-	0	

631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	-	-	0	
632	МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ	-	-	0	
64	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	-	-	0	
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	5	5	0	100
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	5	0	100

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>38,409,295.00</b>	
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>38,409,295.00</b>	
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	38,409,295.00	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	38,409,295.00	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	38,409,295.00	
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>47,889,200.00</b>	
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	<b>47,889,200.00</b>	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	47,889,200.00	

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Булган суман дахь сум дундын Ойн анги нь ойн менежментийг хэрэгжүүлэх, ойн санг хамгаалах чиг үүрэгтэйгээр ажилласан байна.

- "Тэр бум мод" үндэсний хөдөлгөөнтэй холбогдуулан мод, бут тарих ажил нэмэгдэж, хүчний байгууллагууд тарьц, суулгац ургуулах зорилгоор үр, мөчир бэлтгэх үрийн модны плантаци байгуулах ажил гэх мэт үйл ажиллагаан дээр мэргэжил арга зүйн зөвөлгөөг өгсөн байна.
- Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/172,116 тоот тушаалаар баталсан "Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний зардлын нормативыг шинээр болон шинэчлэн батлах тухай" тушаалын дагуу талбай тусгаарлалтын орлого, зардлыг тооцож ажилласан байна.
- Улсын хилийн харлуулсан зурвасыг сэргээх ажлаас гарах зулзаган модыг шилжүүлж суулган төв суурин газрын ногоон байгууламжыг нэмэгдүүлнэ. Насны I, II ангийн шинэсэн ойд арчилгааны ажил хийснээр тухайн ойн ургалт, тэжээлийн талбай, гэрлийн хэмжээ, таваарлаг чанарыг нэмэгдүүлэж шилмэл сор модтой сайн чанасаатай ойг бий болгох хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаандаа Ойн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Татварын багц хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Байгаль орчны тухай хууль болон түүнийг дагалдаж гарсан тогтоол, дүрэм журам, эрх бүхий албан тушаалтнуудын шийдвэрүүдийн хэрэгжилтийг ханган үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирохгүй байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон НБББББ батлаагүй, аймгийн Засаг даргын 2020 оны А/424 дугаар захирамжаар баталсан бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 88,557,8 мянган төгрөгөөр буюу 166 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	0	13329,6	13,329.6
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	17,268.7	28,557.5	(11,288.8)
Үндсэн хөрөнгө	35,837,4	99876,7	(64,039.2)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>53,106,1</b>	<b>141,663,8</b>	<b>(88,557,7)</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	53,106.1	141,663.8	(88,557,7)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>53,106,1</b>	<b>141,663.8</b>	<b>(88,557,7)</b>

Дээрх хүснэгтээс харахад тайлант онд ойн талбай тусгаарлалтын 13,329.6 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй гарсан байна.

Тусгай зориулалтын бараа материал худалдан авч бэлтгэснээр өмнөх оноос бараа материал 11,288.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Элэгдлээрээ өртөгөө нөхсөн 5 нэр төрлийн 3,117.4 мянган төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж данс бүртгэлд тусгасан байна. Аймгийн ИТХ-ын 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор 6 нэр төрлийн 37,604.8 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч, Байгаль орчны яамнаас хуваарилсан трактор, дагалдах хэрэгсэл 42,200.0 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлт тусгажээ.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 88,502.9 мянган төгрөг, өөрийн орлогоос 13,5 мянган төгрөг нийт 102,002.9 мянган төгрөгийг бүрдүүлэхээр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаар зардлыг 38,216.1 мянган төгрөгөөр, өөрийн орлогоос 15,000.0 мянган төгрөг нийт 53,216.1 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 72,356.2 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна. Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 61,100.0 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 61,100.0 мянган төгрөг буюу 80.6 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 11,256.2 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/Д	Хөтөлбөр арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Арга хэмжээ				
<b>Нийт дүн</b>			<b>72,356.2</b>	<b>61,100.0</b>	<b>11,256.2</b>	<b>80,6</b>
1	7140 3	80101	58,046.1	46,789.9	11,256.2	80.6
3		80112	4,896.7	4,896.7	0	100.0
4		80802	9,413.4	9,413.4	0	100.0

/мянган төгрөгөөр/

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

№	Эх үүсвэр	Мөнгөн дүн
1	Арчилгаа огтлолтын зардал	9,990.0
2	Аймгийн Засаг даргын А/270 дугаар захирамжаар Тэшиг, Сэлэнгэ суман дах хилийн зурвасын трасст өртөж буй зулзган мод шилжүүлж суулгах зардал	28,419.3
		38,409.3

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган суман дахь сум дундын Ойн ангийн 2022 оны 12

дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Анхбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган суман дахь сум дундын Ойн ангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 16 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвөөс 137,060.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 2,055.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 1,541.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Хуулийн 15 дугаар зүйлд заасан хэмнэлтийн бусад арга хэмжээтэй холбоотой зардлуудыг санхүүжүүлээгүй байна. Хуулийн 20 дугаар зүйлийн тайлагнал, ил тод байдлын 20.5 -д заасан этгээд шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор

www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны тухай хуульд заасан нийт 152 мэдээлэл мэдээлэхээс хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

*Шийдвэрлэсэн нь:* Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Тайлант хугацаанд завсрын аудит хийгдээгүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж гараагүй байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Аудитын гүйцэтгэх цаг хугацааны нөөц, цар хүрээ хязгаарлагдмал байсан учраас дараагийн санхүүгийн тайлангийн аудитаар бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдэлд бүрэн тооллогын горим сорил хэрэгжүүлэн, өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны тайлан, 2022 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын тайланд дурдсан зүйлсийг шийдвэрлэсэн байдал зэргийг тусгайлан авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

---

Аудитаар нийт 12,318.2 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 328.4 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгч, 11,989.8 мянган төгрөгийн алдааг залруулсан.

#### **5.1 Төлбөрийн акт**

Төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

#### **5.2 Албан шаардлага**

1. Байгууллагын данснаас актлаж буй эргэлтийн хөрөнгийг тушаал шийдвэргүйгээр хассан.

Энэ нь ТӨБЗГ-ын 2018 оны 86 дугаар тогтоолын баталсан "Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам"-ын 3.5 д "Төрийн өмчийн эргэлтийн

---

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хөрөнгөд хамаарах эд хөрөнгийг шилжүүлэх, худалдах, акталж, данснаас хасах асуудлыг өмч хамгаалах зөвлөл судлан дүгнэлт гаргах бөгөөд хуулийн этгээдийн удирдлагын тушаалаар шийдвэрлэнэ. Өмч хамгаалах зөвлөл шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг гүйцэтгэнэ” гэсэн заалттай нийцээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Зөрчлийг арилгаж давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Зардлын данстай холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Анхан шатны баримт материалын бүрдүүлэлт дутуу буюу шаардах хуудасны гарын үсэг, тамга, тэмдэг дутуу байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.4, 13.5, 13.6, 13.7 зэрэг заалтуудад нийцээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: : Анхан шатны баримт материалын бүрдүүлэлтийг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үр дүнгийн тайлангийн зарлагыг илүү тусгасан	1	11,989.8			1	11,989.8	1	11,989.8				
Дүн	1	11,989.8			1	11,989.8	1	11,989.8				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Байгууллагын данснаас актлаж буй эргэлтийн хөрөнгийг тушаал шийдвэргүйгээр хассан.	1	328.4			1	328.4	1	0				
Анхан шатны баримт материалын бүрдүүлэлт дутуу буюу шаардах хуудасны гарын үсэг, тамга, тэмдэг дутуу байна.	1	0										
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>328.4</b>			<b>1</b>	<b>328.4</b>	<b>1</b>	<b>0</b>				